**Population teaching, training and research in Mongolia - R. N. Pandey**

Though sporadic attempts were made in Mongolia for the study and research in the field of the population in the past but systematic efforts started only after the setting up of Population Teaching and Research Center (PTRC) at the Mongolian National University in 1992 with financial support from the United Nations Population Fund (UNFPA). This paper gives in brief the activities undertaken so far by the PTRC in teaching, organising short term training programmes for senior officers from other organizations and conducting research in priority areas of population concerns. Within a short period of it's existence, the PTRC has done tremendous job but much more remains to be done which it will try to accomplish in the next four years.

**Determinants of infant and child mortality in Mongolia - B. Bayasagalan**

In this paper an attempt has been made to investigate the differentials of infant and child mortality by socio-economic, demographic and environmental characteristics and to identify the main determinants that affect the level of infant and child mortality. The data from 1994 Demographic Survey of Mongolia has been extensively used for carrying out various statistical analysis. The analysis reveals that general level of infant and child mortality was quite high even among groups such as mothers with educational levels of 9-10 grade. The level is much higher than the average levels in countries with similar level of socio-economic development such as China and Cuba. It has been suggested that promoting health education among mothers may prove to be one of the most cost effective measure in reducing infant and child mortality in Mongolia. The use of family planning services and educational campaign with respect to these services still need to be greatly encouraged in other avoid pregnancies in the high risk age group (15-20 and 35+ ). Well organised family planning services and their integration with other maternal and child health services could be one possible way of promoting health education among mothers.

**Socio-economic characteristics of Mongolian population - Important findings from Demographic Survey of Mongolia - R. N. Pandey**

During October - November, 1994, the Population Teaching and Researching Center conducted a largescale demographic survey covering 1763 households and 2,000 women and 1,000 men spread in 5 aimaks (province) and the capital city of Ulaanbaatar. This paper gives important findings of this survey relating to various socio-economic and demographic characteristics of the survey population such as age-sex distribution, marital status, educational attainment, exposer to mass media , perception of population change and economic situation. Wherever possible comparison with data from other sources such as census and civil registration have been also attempted. It is very interesting to note that about 40% of the population have the impression that Mongolian population is decreasing. Even for about 50% of the respondents who reported population to be increasing, the growth is too slow.

**Projection of Population for Mongolia - D.Gankhuyag**

This paper had tried to work out population projections for Mongolia for the period 1989 - 2019 by using component method and different assumptions about the changes in fertility and mortality during this period. The paper has also attempted the projections for labour force and school going population. The findings of the paper reveal that the population of the Mongolia will not be more than 2.5 million by the term of the century. It will be somewhere between 2.9 and 3.2 million by the year 2019 depending upon the pace of fertility and mortality decline. The age structure is likely to have substantial change with the increase of old age people and working age people. The paper suggest that there is

necessity of giving more importance to population dynamics in policy making and development planning of the country.

### Recent urbanization trends in Mongolia - S. Batbileg

Very few publications about urbanization in Mongolia are available. In this paper the present levels, trends and patterns of urbanization have been studied. The major factors affecting urbanization process have been identified and it's effect on socio-economic development have been also investigated. Annual population growth in urban areas was three times the rate in rural areas in both 1969-79 and 1979-89. In Darhan and Erdenet , the increase was exceptionally high. The data suggest that migration has been a major component of urban population growth. Between 1969 and 1989 urbanization was centered mainly in places that could be considered medium sized cities with population of 20,000 to 100, 000. Governmental and economic transformations since the 1980s has seriously slowed down economic growth leading to privatization if agricultural activities and eliminated administrative restrictions on movements. These changes are likely to result in increase in urban growth.

### Trends and pattern of mortality in Mongolia and it's comparison with some other developing countries - Ts. Bolormaa

In this article an attempt has been made to analyse the levels and trends of mortality during 1969-1995. For this analysis, CDR, ASDR, IMR, life expectancy at birth have been considered. Inspite of good health infrastructure in Mongolia, the level of maternal mortality rate has been higher as compared to other similarly placed countries. Paper tries to explore the possible reasons for this. Important determinants of infant and child mortality as well as maternal mortality have been also identified. For improving the mortality situation in Mongolia, the emphasis on mothers education and prevention of higher ordered births have been recommended.

### Impact of development on the status of women- some thoughts - A. Solongo

The women in most of the countries of the world are at disadvantage as compared to men because of various socio-economic and cultural factors. This article brings out the gender differences by comparing the values of a number of indicators pertaining to health, poverty, employment, income etc. for men and women. Detailed analysis have been made of the time spent on houshold work by men and women. It has been found that for all the countries under study, the average time spent by women on vaious household activities was 3 times more as compared to men. The difference is more glaring in cooking and taking care of children.

### Family structure in Mongolia - O. Sukhbaatar

The family structure in every society is output of various socio-economic-demographic and cultural factors. In this paper detailed analysis of family structure (number of children per houshold ) in Mongolia has been made by considering rural-urban, aimag and marital status variables. An interesting analysis of change in family structure after the transition of the country to market economy can be also seen in this paper. It has been mentioned in the paper that the number of women headed households, with 6 and more children, more than doubled during the period 1990-1994.

### Determinants of migration in Arhangai aimag (province) of Mongolia - A. Amarbal

Analysis of magnitute of migration in different aimags of Mongolia on the basis of census data for the period 1969-1979 and 1979-1989 reveal that Arhangai has been the most outmigrating aimag.

This paper tries to find out the possible reasons for high out migration in this aimag. By using the records of the outmigrating people with the police authorities, age, sex, reasons for migration and education of migrants were studied. It has been found that about 50 % of the outmigrants were in the age group 16-30. Approximately 1/4 of the outmigrants were having higher-professional education. The lesser employment opportunities and poor living conditions were mentioned as the main reasons for outmigration.

**Mathematical models of population growth - Ts. Bolorchimeg**

By using the well known mathematical models, this paper has projected the population of Mongolia for the period 1995 to 2019. The projected population in 2019 varies from 3.33 million as per exponential model to 3.60 million as per Gompertz model. In the next step two new mathematical models have been developed for the periods 1918-1940 and 1950-1994 because of the different pattern of the population growth rate during these periods. Projections from these models have been also compared with those from well known mathematical models.

**Health issues specific to women in Mongolia - J. Doljinsuren**

By studing the trend in number of births by geograpical areas, age at first birth, birth interval by the age of mothers and contraceptive prevalence rate some health issues specific to women have been identified. A comparison of some of these indicators have been made for Mongolia, Pakistan and Romania. For these comparison, the data available from Demographic Surveys in these three countries have been used. The training of the teenagers about the STD and the use of contraceptive methods to avoid early pregnancy have been some of the important recommendations of the paper.

**Levels and trends of unemployment in Mongolia - Kh. Odgerel**

After the transition of Mongolia to market economy the levels of unemployment is on rise. Based on the data from SSO the paper has tried to study the trend of unemployment during the period 1991-1995. Analysis has been carried out by aimag, region, duration of unemployment, educational level of unemployed etc. The impact of demographic varaibles on the level of unemployment have been also examined. As unemployment is of recent phenomenon for Mongolia, suitable concepts and definitions have to be evolved to create sound data base for the study of unemployment in Mongolia.

**Standard of living and poverty in Mongolia - B. Enkhtsetseg**

In 1995, 361.7 thousand families out of total 514.1 thousand in Mongolia were below poverty line. This paper attempt to study the trend in poverty during the period 1994-1995. The paper also discusses the concept used in defining the poverty. By using the data from family expenditure survey an analysis about the living conditions of the people have been also attempted. Based on the analysis of the paper some reorientation in the implementation of poverty alleviation programme in Mongolia has been suggested.

**Монгол дахь хүн ам зүйн сургалт ба судалгаа**
**Р. Н. Панди**

Урьд өмнө нь Монголд хүн ам зүйн салбарт шинжилгээ судалгааны ажлыг тодорхой түвшинд хийгдэж байсан боловч чухамхүү системтэй сургалт, эрдэм шинжилгээний ажлыг 1992 оноос НҮБ–ын Хүн амын сангийн тусламжтайгаар МУИС–ийн дэргэд байгуулагдсан ХАЗССТ–ийн байгуулагдснаас хойш эхэлсэн юм. Энэ өгүүлэлд ХАЗССТ байгуулагдснаас хойших богино хугацаанд хийж гүйцэтгэсэн болон ирэх дөрвөн жилд хийхээр зорилт болгон төлөвлөж буй үйл ажиллагааны талаар тодорхойлохыг оролдсон юм.

**Монгол дахь нярайн болон хүүхдийн эндэгдлийн ялгавартай түвшин**
**Б. Баясгалан**

Энэхүү бүтээлдээ нярайн болон хүүхдийн эндэгдлийн түвшинг нийгэм эдийн засаг, хүн ам зүй ба байгаль орчны ялгавартай байдлаар судлан шинжлэхийг оролдсноос гадна түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлсон юм. 1994 онд хийгдсэн Монголын хүн ам зүйн судалгааны мэдээллийг статистик боловсруулалт хийхдээ өргөн ашигласан. Хүүхэд ба нярайн эндэгдлийн ерөнхий төвшин бүрэн дунд боловсролтой эхчүүдийн дунд ч ихээхэн өндөр байгааг энэ судалгааны үр дүнд илрүүллээ. Нийгэм эдийн засгийн хөгжлийн ойролцоо түвшин бүхий Хятад болон Кубын хүүхэд болон нярайн эндэгдлийн дундаж түвшинтэй харьцуулбал илүү өндөр байна. Эхчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх явдал нь Монгол дахь хүүхэд болон нярайн эндэгдлийг багасгах хамгийн үр дүнтэй арга хэмжээ гэж үзсэн. Ялангуяа, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх болон боловсрол олгох үйл явцийг эндэгдлийн түвшин харьцангуй өндөр насанд, тодруулбал 15–20 болон 35–аас дээш насны эхчүүдэд хандуулах нь зүйтэй болов уу.

**Монголын хүн амын нийгэм эдийн засгийн шинж байдал**
**Р.Н. Панди**

1994 оны 10–11–р сарууддад Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны төвөөс эрхлэн 5 аймаг болон Улаанбаатар хотын 1763 өрхийн 2000 эмэгтэй ба 1000 эрэгтэйг хамарсан өргөн хүрээтэй хүн ам зүйн судалгаа явуулсан. Энэ бүтээлд нас хүйсийн бүтэц, гэрлэлтийн байдал, боловсролын түвшин, хүн амын мэдээллийн хүртээл, хүн ам болон эдийн засгийн өөрчлөлтийн талаарх үзэл санаа зэрэг нийгэм–эдийн засаг– хүн ам зүйн шинж байдлуудыг хүн ам зүйн судалгааны мэдээлэлд шинжилгээ хийж тодорхойлсон. Ингэхдээ хүн амын тооллого, иргэний бүртгэл зэрэг бусад мэдээллийн эх үүсвэрүүдээс гаргасан баримтуудтай бололцооны хэрээр харьцуулан үзэхийг оролдсон юм. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 40 хувь нь Монголын хүн ам буурч байна гэсэн сэтгэгдэлтэй байгааг тэмдэглэхэд ихээхэн сонирхолтой байна.

**Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо**
**Д. Ганхуяг**

Тус өгүүлэлд 1989–оны хүн амын тооллогын мэдээллийг үндэслэн 2019 он хүртэлх Монголын хүн амын хэтийн тооцоог тодорхой үеийн төрөлт, нас баралтад гарсан өөрчлөлтийг ашиглан хэд хэдэн таамаглал дэвшүүлэн

бүрэлдэхүүний аргаар боловсруулан хийсэн. Түүнчлэн ажиллах хүчний болон сургуульд сурагчдын хэтийн тооцоог хийхийг оролдсон юм. Дээрх тооцооноос үзвэл Монголын хүн ам энэ зууны эцэст 2.5 саяаас хэтрэхгүйг харж болно. Мөн түүнчлэн хүн амын төрөлт нас баралтын өөрчлөлтийн тодорхой чиг хандлагуудаас хамааран Монголын хүн ам 2019 он гэхэд 2.9–3.2 саяын хооронд хэлбэлзэнэ гэсэн үр дүн гарчээ. Энэ бүтээлд хүн амын тоо, бүтцийн өөрчлөлт нь бодлого боловсруулах болон нийгэм–эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд нэн чухал ач холбогдолтой гэдгийг онцлон тэмдэглэсэн юм.

**Монгол дахь хотжилтын чиг хандлага**
**С. Батбилэг**

Монгол дахь хотжилтын асуудлыг авч үзсэн судалгаа тун цөөхөн байдаг.Энэ бүтээлд хотжилтын одоогийн түвшин, хандлага, хэв маягийг судалснаас гадна хотжилтын үйл явцад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлоод, тэдгээрийн нийгэм–эдийн засгийн хөгжилд үзүүлж буй нөлөөллийг судалсан байна.1969–1979 буюу 1979–1989 онуудын жил тутмын хүн амын өсөлтийг авч үзэхэд хотын хүн амын өсөлт нь хөдөө орон нутгийнхаас хэд дахин илүү байна. Тухайн үед хотын хүн амын өсөлтийн гол бүрэлдэхүүн хэсэг нь шилжих хөдөлгөөн байсан юм. 1969–1989 оны хооронд хотжилт нь гол төлөв 20–40 мянган хүн ам бүхий дунд зэргийн хэмжээний хотуудад төвлөрсөн байна.1980–аад оноос засаг захиргаа, нийгэм–эдийн засгийн бүтцэд гарсан томоохон өөрчлөлтүүд нь Монголын хотжилтын дүр төрх, үйл явцад ихээхэн нөлөөлсөн юм.

**Монголын хүн амын нас баралтын түвшний хандлага түүнийг хөгжиж буй орнуудын түвшинтэй харьцуулах нь**
**Ц. Болормаа**

Энэ өгүүлэлд Монголын хүн амын нас баралтын ерөнхий түвшин, чиг хандлага, дундаж наслалт, эхийн эндэгдэл, нялхас, хүүхдийн эндэгдлийн ялгавартай байдлын тухай өгүүлэхийг зорилоо. Мөн тус улсын хүн амын нас баралтын түвшин, хандлагыг хөгжиж буй зарим орнуудтай харьцуулж, шинжилгээ хийлээ.

**Хөгжил дэх эмэгтэйчүүдийн статусын нөлөөлөл**
**А. Солонго**

Өнөөдөр дэлхийн олонхи орнуудад эмэгтэйчүүдийн байдлыг нэлээд өндөр түвшинд авч үзэх болжээ. Энэ нь хүн амын аливаа хөтөлбөрийн хэрэгжилтэнд чухал нөлөө үзүүлж байгаагаар тайлбарлагдаж байна. Иймд хүн ам, хөгжлийн төлөвлөлтөд хүйсийн асуудлыг онцгойлон анхаарч, үнэн зөв ойлголттой болж чадвал бид амжилтанд хүрнэ. Энэ зорилгын үүднээс цуврал лекцийнхээ анхны дугаарыг толилуулж байна.

**Монголын гэр бүлийн бүтцийн зарим тоон үзүүлэлт**
**О. Сүхбаатар**

Аливаа улс орны гэр бүлийн нийтлэг бүтэц, хэв маяг, шинж байдал нь тухайн нийгмийн онцлогийг харуулах нэг дүр зураг болдог. Монгол Улсын гэр бүлийн бүтцийн зарим тоон үзүүлэлтийг динамикаар авч судлан, өөрийн үнэлэлт, дүгнэлтийг өгч, цаашид төрөөс баримтлах ХАЗ–н бодлогод санал бодлоо дэвшүүлсэн.

**Архангай аймгийн хүн амын шилжих хөдөлгөөнд хийсэн судалгаа**
**А. Амарбал**

Шилжих хөдөлгөөн нь хүн амын өсөлт өөрчлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд, ялангуяа бүс нутгийн түвшинд энэ байдал илүү тод ажиглагддаг. Тус өгүүлэлд Архангай аймгийн хүн амын шилжих хөдөлгөөнийг Иргэний Бүртгэл Мэдээллийн ХААТР–24 маягтаас 1991–1995 оны хоорондох хугацаанд авч судлан, өмнөх судалгааны дүгнэлтүүдтэй харьцуулан үзэж, шилжих хөдөлгөөний мэдээллийг боловсронгуй, нарийн болгоход цаашид анхаарах саналуудыг дэвшүүлсэн.

**Хүн амын өсөлтийн математик загвар**
**Ц. Болорчимэг**

Энэ бүтээлд Монгол улсын хүн амын өсөлтийн өнгөрсөн, өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагыг судалж, түүнд үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр хүн ам зүйд математикийг хэрхэн ашиглаж болохыг тодорхойлж, Монголын хүн амын өсөлтийг математик загваруудаар гаргаж, тэдгээрийн хуулийг зохиохыг хичээсэн юм. Эдгээр хуулиудаар хүн амын өсөлтийн хэтийн тооцоог хийсэн юм.

**Монголын эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн зарим асуудлууд**
**Ж. Должинсүрэн**

Шилжилтийн үеийн Монголын эмэгтэйчүүдийн байдалд дүгнэлт хийж, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаархи мэдээлэл, судалгаанд үнэлэлт өгөхийг зорив. Мөн өөрийн орны эмэгтэйчүүдийн талаархи судалгааг мэдээллийн боломжийг харгалзан зарим орны ижил төстэй судалгаануудтай харьцуулж үнэлгээ, саналуудыг гаргасан.

**Монгол дахь ажилгүйдлийн төлөв байдал, хандлага**
**Х. Одгэрэл**

Монгол дахь ажилгүйдлийн түвшин, чиг хандлага, шалтгаан, онцлог төлөв байдлын талаар бичиж түүнийг бууруулах арга замыг тодорхойлохыг хичээлээ. Мөн ажилгүйдэлд нөлөөлж буй нийгэм –эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлсийн нөлөөллийг тооцож ,үнэлэлт дүгнэлт өглөө.

**Монголын хүн амын ядуурал ба амьжиргааны байдал**
**Б. Энхцэцэг**

Монголын хүн амын ядуурал, түүний шалтгаан, өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт хийж, түүнийг бууруулах арга замын талаар өөрийн саналыг тусгасан. Мөн Монголын хүн амын амьжиргааны байдлын талаар танилцуулга хийлээ.

---